

Монгол хэлний өгүүлбэрийн өргөлтийг дууны ухааны илрэлээр шинжлэх нь

Ван Гуу Бин*

Өвөр Монголын Үндэстний Их сургууль,
Монгол судлалын дээд сургууль,
Хэл шинжлэлийн тэнхим

Хураангуй

Уламжлалт хэл шинжлэлд авиа зүйн судалгааны арга зүй хоцронгуй байдаг учраас монгол хэлний өгүүлбэрийн өргөлт чухам хаана байх тухай эрдэмтдийн үзэл нэгдмэл биш байна. Өргөлт нь үгийн нэгдүгээр үе эсвэл бусад үе дээр байх тухай эрдэмтдийн үзэл хоорондоо харилцан адилгүй байна. Өргөлтийн мөн чанар бол ярианы төвлөрсөн хэсгийн авианы талаар илрэх хэлбэр мөн ч хэл ярианы урсгал дунд авиалагчийн дамжуулах гэж байгаа гол утга санаа мөн.

Физиологийн үүднээс авч үзвэл өргөлт нь голдуу авиалагч нь өгүүлэх эрхтний булчингийн нэн их чангарал байж өргөлтгүй үеийг бодвол энерги зарцуулах хэмжээ нь нэн их байдаг нь зайлшгүй. Иймээс дууны өндөрц нь товойм, дууны хүчилц нь чангарах жич авианы урт нь илэрхий уртатгах бүхий л цогцын чангарал болно.

Өгүүлбэрт зарим нэг авиа харьцангуй тод чанга авиалж зарим авиа сулавтар авиалах эсвэл зарим үгийг нь бусдаас чанга авиалж өгүүлбэрт утга ялгах үүргээ гүйцэтгэдэг. Өгүүлэлд өгүүлбэрийн өргөлтийн тухай судалгааны байдлыг танилцуулж өргөлтийн өгүүлбэрт үзүүлэх үйлдлийг тодорхойлж “мал нь тарга хүчтэй сайн байсан юм” гэх өгүүлбэрээр жишээлж дууны өндөр ч, дууны хүчилц ч, дууны урт ч зэрэг гурван элементийг дууны ухааны задлалтын программ (ргаат) ашиглан задлалт хийж өгүүлбэрийн аяс ба өргөлтийн хамгийн чухал болох дууны ухааны илрэх хэлбэр бол дууны үндэс болох мөртөө өргөлт нь өгүүлбэрийн илрэх чухал арга хэлбэр болохыг нотлон гаргажээ⁴⁰.

Түлхүүр үг

Өргөлт, дуун ухаан, өндөрч, авиа зүй

Удиртгал

Уламжлалт авиа зүй удаан жил хөгжөөд зөвхөн “чих, ам”-ыг түшиглээд цааш урагшлахад хэцүү байдалд орж байна. Иймээс монгол хэлний уламжлалт авиа зүйг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь чухал. Ийнхүү дэлхий дахинаа үг ярианы дууны ухааны инженеринг ихээр хөгжиж ямар нэг хэмжээгээр хүн-машин авиагаар хэрэглэх болж байна. Уламжлалт авиа зүйд дурдагдаагүй шинэ онол, онол үйлдлийн асуудал дурдагдаж байна. Жишээлбэл: монгол хэлний өргөлт гэж чухам юу юм бэ гэдэг асуудал гарч ирэв. Хэрэв үгийн нэгдүгээр үед хүчлэг өргөлт үгүй бол эгшиг зохицох ёсыг юу гэж тайлбарлах юм бэ? гэдэг онол-үйлдлэх асуудал дурдагдаж байна (Баярмэнд, 2012, х.32). Энэ асуудлыг зүгээр таньж тодорхойлох нь эрдэм шинжилгээний ажилд чухал болохоор барахгүй мөн үг ярианы дуун ухааны инженеринг мөн чухал суурь болно.

Хэлний харилцаанд хүмүүс авиануудыг

холбон авиа үүсэж байдаг. Тэгэхэд зарим нэг авиаг харьцангуйгаар тод чанга авиалж, зарим авиаг сулавтар авиалах, эсхүл зарим үгийг нь бусдаас чанга хүчтэй хэлэх үзэгдэл тохиолдоно. Гэхэд хэлний авианы чанга сул нь нэг зүйлийн мэдрэмжийн төрүүлж болсны хувьд тэр зохих бодисын сууринд хэрэглэгддэг. Физиологийн үүднээс авч үзвэл, өргөлт нь голдуу авиалагчийн өгүүлэх эрхтний булчингийн нэн их чангарал байж, өргөлтгүй үеийг бодвол энерги зарцуулах хэмжээ нь нэн их байдаг нь зайлшгүй. Иймээс дууны өндөрц нь нэн товойм, дууны хүчилц нь нэн чангарах жич авианы уртац нь нэн илэрхий уртатгах бүхий л цогцын чангарал болно.

Өргөлтийн мөн чанар бол хэлний ярианы төвлөрсөн хэсгийн авианы талаарх илрэх хэлбэр мөртөө хэл ярианы урсгал дунд авиалагчийн дамжуулах гэж байгаа сураг чимээ гол утга санаа мөн. Иймээс өргөлтийг ч мөн үг ярианы

⁴⁰Тус өгүүлэл Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн сурган хүмүүжлийн төсөв “Web-д суурилсан монгол хэлний шалгалтын программыг судлах нь” (YB2018025) энэ төсвийн дэмжлэгийг хүртэв.

*Холбоо барих зохиогч: 66811344@qq.com

төвлөрсөн хэсгийн өгүүлбэрийн аяс айзам дах илрэх хэлбэр мөн гэж үзэж болно. Урьдах хүмүүсийн судалгаанаас үзвэл олонх эрдэмтэд өргөлт нь зөвхөн дууны хүчилцийн чанга султай холбогддог гэж үзэж байжээ. Монгол хэл жишээлсэн ч Монгол хэлний өргөлт бол нэгдүгээр үе дэх хүчлэх өргөлт мөн гэх үзэлт олон дурдагддаг байсан. Гэтэл, олонх хэлний судалгаанд, онцгойлон ойрын жилүүдийн дууны ухааны туршилтын судалгааны гэрчилсэн нь, хэлний авианы чанга сул нь ч бусад ч дээрээ ерөнхийлсөн дууны чадавхын их багаар илэрч байдаг. Тэр дууны өндөрцтэй нэн их харьцаатай байж, харин урьдах хүмүүсийн ярьдаг шиг зөвхөн дууны хүчилцийн чанга султай холбогдолтой биш. D.B Фрай-ийн 1955 он ба 1958 оны туршилт жич Болингер-ийн туршилтын үр дүн нь энгийн ярианы хэлний өргөлтийн чухал шинж тэмдэг болох дууны өндөрц бол өгүүлбэрийн өргөлтийн үндсэн бэлтгэх арга мөн гэснийг гэрчилсэн байна.

Монгол хэл бол эгшиглэнт хэл биш монгол хэлний өргөлт нь үгсийн сангийн утгыг илтгэхгүй мөртөө хэлбэр зүйн утгыг ч илтгэдэггүй. Иймээс монгол хэлэнд өргөлт байх эсэх нь тийм чухал биш. Харин хамгийн чухал нь дууны өндөрц, дууны хүчилц зэрэг олон элементүүдийн монгол хэлний үгсийн дундах тархалтын motel, тархалтын жим хууль, жич тэдгээрийн өргөлттэй үеийг хэрхэн нөлөөлөх асуудал болно. Нэн чухал түүхэн харьцуулсан авиа зүйн зогскоос хэлбэл үгийн өргөлт нь монгол хэл цаашлан хэлний дууны ухааны инженерчлэл шинжлэх ухаанч, гэрч баримт олгох явдал болох бөгөөд тус асуудлыг шийдвэрлэх нь мөн ч монгол хэл цаашлан алтай язгуур хэлний түүхэн харьцуулсан авиа зүйн судалгааг түлхэн ахиулдаг юм.

Судлагдсан байдал

Монгол хэлний өгүүлбэрийн өргөлтийн судалгааны байдлыг тодорхойлбол:

1. Уламжлалт хэл шинжлэлд аль эрт “Одоо үеийн Монгол хэл” 1964 онд өгүүлбэрийн аяс айзмын тухай анзаарсан мөртөө энгийн үг ярианы өгүүлбэрийн хэсэг, завсарлалд хийгээд өгүүлбэрийн өргөлтийн тухай дурдаж өнгөрөөжээ. Үүнд өгүүлбэрийн өргөлтийн тухай тодорхойлохдоо, өгүүлбэрийн өргөлт гэж өгүүлбэрийн дотор хамгаас сайн чанга хэлэгдэх авиаг хэлнэ. Түүнийг хэлний зүйн өргөлт хийгээд утгын өргөлт гэж ангилна. Аяндаа чанга хэлэгдэх авиаг хэлний зүйн өргөлт буюу айзмын өргөлт гэнэ. Хэлний зүйн бүтэцтэй хамаагүй, голдуу утга санаа хийгээд сэтгэлгээний талын

учир шалтгаанаас болж, аль нэг авиаг зориуд чангаар хэлснийг утгын өргөлт буюу чухалчлах өргөлт гэнэ. Утгын өргөлтийг бас логикийн өргөлт, сэтгэлгээний өргөлт гэж нарийн хувааж болно. Хэлний зүйн өргөлт бол олонхдоо үгийн өргөлттэй шинж чанарын талаар ойр байдаг. Ерийн богино өгүүлбэрт, олонхдоо өгүүлбэрийн эхэнд нэг л өргөлттэй. Иймээс ийм энэ богино өгүүлбэр нь өгүүлэгдэхүүн өгүүлэхүүнээр бүрэлдсэн юм бол, өргөлт өгүүлэгдэхүүнд ногдоно. Хэрвээ тусагдахуун буюу байц хийгээд өгүүлэхүүнээр бүрдсэн юм бол, тусагдахуун буюу байцад ногдоно. Ерийн урт өгүүлбэрт, их төлөв өгүүлбэрийн хэсгүүдийн эхний үе нь тус тус чанга шиг хэлэгдэнэ. Иймээс тодотгол, тусагдахуун, байц бүхий холбоо үгэнд тодотгол, тусагдахуун байцын эхний үе нь чанга шиг хэлэгдэнэ. Асуух өгүүлбэрийн асуух төлөөний үг, хориглох өгүүлбэрийн хориглох сул үгийн өргөлт бусад үгийн өргөлтөөс нэн чанга хэлэгдэнэ. Бас ерөөх, орлох өгүүлбэрийн өргөлт нь маш чанга байдаг юм (Богуйлан, 2017, х.21).

Логикийн өргөлтөд дээр дурдсан хэлний зүй хэлний зүйн өргөлтийн шиг журам ёс гэж үгүй, харин утга санааны шаардлагаар харьцангуй чөлөөтэй хэрэглэгдэнэ. Логикийн өргөлт бүхий үгэнд, логикийн өргөлт хамгаас чанга хэлэгдэж, хэлний зүйн өргөлтүүд нь дэслэх байрыг эзлэх болно гэжээ. Дараалбал “Орчин үеийн монгол хэл” (2007)-д тодорхойлсон нь.

Судалгааны арга зүй


Тус өгүүлэлд дууны ухааны задлалын программ (praat) ашиглан бодитой өгүүлбэрээр жишээлж дууны гурван элемент дууны хүчиллэг, дууны өндөр, дууны урт зэргээр задлал хийсэн болно.

Өгүүлбэр дэх аль нэг үг буюу гишүүнийг бусдаас нь хүчтэй хэлэхээр илрэх үзэгдлийг өгүүлбэрийн өргөлт гэнэ. Өгүүлбэрийн өргөлтийг үүрэг үйлдлээр нь (буюу хэл зүйн) өргөлт, логикийн өргөлт гэж хоёр төрөлд ангилна. Өгүүлбэрзүйн өргөлт нь өгүүлэгчийн санаа зорилгыг тодорхойлохоор өгүүлбэр дэх аль нэг үг буюу өгүүлбэрийн гишүүнийг чанга хүчтэй хэлэх үзэгдэл байж, хүүрнэх өгүүлбэр болон энгийн маягаар шаардан захирах өгүүлбэрийн өргөлт голдуу өгүүлбэрийн эхний хэсгийн үг дээр байдаг (Бохуайчил, 1989, х.30). Ийм учраас тэдгээр өгүүлбэрийн эцсийн аяс нь нам болж байдаг. Асуух өгүүлбэрийн өргөлт нь голдуу түүний бүтэц дэх асуулт төлөөний үг буюу асуух сул үг дээр тусна. Чанга тодорхой тушаасан захирах

өгүүлбэр болон анхааруулах өгүүлбэрийн өргөлт нь голдуу өгүүлбэрийн сүүлийн хэсгийн үгнүүд дээр голлон тусдаг. Иймээс эдгээр өгүүлбэрийн эцсийн аяс нь өндөр байдаг. Логикийн өргөлт гэж өгүүлбэрийн агуулгын голдлогыг товойлгон чухалчлах шаардлагаар өгүүлбэр дэх аль нэг үг буюу гишүүнийг чанга хүчтэй хэлэх үзэгдэл болно. Үүнээ мөн “утгын өргөлт” гэж нэрлэдэг.

Зураг 1

Дууны өндөрц



2. Ойрын жилүүдэд авиа таниулах, авиа нийлүүлэх зэрэг хэлэхүйн инженеригийн мэргэжлийн судалгааны шаардлагаас болж монгол хэлний өгүүлбэрийн аялгын судалгаа нь ч шинэ цаг үеийн шаардлага ёсоор эрдэмтэн мэргэжилтэнд чухалчлагдан судлан юм. Үүнд “Монгол хэлний авианы туршилт судлал” (Хөх, 2009), “Монгол хэлний баримжаа авианд суурилсан уншлагын материалын өгүүлбэрийн тэнцэх хэмжээний судлал”, “Монгол хэлний хүүрнэх өгүүлбэр хийгээд асуух өгүүлбэрийн аясыг харьцуулах нь”, “Монгол хэлний хүүрнэх өгүүлбэрийн аясыг тэнцэх хэмжээг шинжлэх нь”, “Монгол хэлний уншлагын материалын өгүүлбэрийн өргөлтийн туршилт судлал” (Ванг Шү Чин, 2008), “Авиа нийлүүлэлтэд хадгалсан монгол хэлний аялгын онцлогийн судалгааны бор төлөв” (Хөх, Хасчимэг, 2007), “Монгол хэлний уншлагын материалын давхаргын нэгж жич заагийн дуун ухаан болон авиа зүйн сүвэгчлэл”, “Монгол хэлний аялгын хэлхцийн төрөлжүүлсэн судалгаан” (Номин, Баярмэнд, Шиюүн Зе Иүй, 2013), “Монгол хэлний чөлөөт ярианы аялгын хэлхэц жич түүний дууны өндөрцийг шинжлэх нь” (Аянга, 2016) зэрэг судалгааны бүтээлүүд буй (Бойжуй, Мөнхбучи, 2008, х.12).

Өгүүлбэрийн өргөлтийн судалгаанд холбогдох нь “Монгол хэлний авианы туршилт судлал”, “Авиа нийлүүлэлтэд хандуулсан монгол хэлний аялгын онцлогийн судалгааны бор төлөв”, “Монгол хэлний уншлагын материалын өгүүлбэрийн өргөлтийн туршилтын судлал” зэрэг өгүүллүүд бий. Хөхийн “Монгол хэлний

авианы туршилт судлал”-д аялгын тухай ярихдаа аялгын бүтцэд өргөлт, айзам ба аяс зэрэг бүтэц хамардаг гэж дурдсан байна. Өгүүлбэрийн өргөлт ба өгүүлбэрийн жилийн аясын асуудалд аяс нь өгүүлбэрийн аяс, өгүүлбэрийн өргөлт, зогсолт зэрэг агуулга багтдаг мөртөө өгүүлбэрийн өргөлт ба зогсолтын тархалт хэв шинж нь маш чухал байрыг эзэлдэг. Гэхэд өгүүлбэрийн өргөлтийн тархалтын хэвийн загвар нь өгүүлбэрийн бүтэц ба утгатай нягт харьцаатай байдаг. Өгүүлбэрт ямар нэгэн бүрэлдэхүүнийг нь чухалчлах үед тэрхүү бүхий л аясын давхаргын өргөлтийн хүчдэл бүр нь дээшилж нэг зүйлийн өргөлтийн төвлөрлийн орон болдог гэж чухалчилсан байдаг. Мөн Хөхийн “Авиа нийлүүлэлтэд хандуулсан монгол хэлний аяс айзмын онцлогийн судалгааны бор төлөв”-т өгүүлбэрт чухалчлах өргөлт байх учраас, түүний үндсэн давтамжийн муруй шугамын дууны цараа нь өргөтгөж чухалчлах өргөлт бүхий олон үет үгийн өндөрцийн загвар нь түүний тогтсон ярианы урсгал дахь өндөрцийн загвартай адилхан байдаг. Өндөрцийн, хүчилцийн өгүүлбэрийн чухалчлах өргөлт үзүүлэх үйлдэл нь уртацаас их байдаг. Ванг Шү Чиний “Монгол хэлний уншлагын материалын өгүүлбэрийн өргөлтийн туршилт судлал” нь уншлагын материалд суурилж, хэлний зүйн өргөлтөөр гол судлагдахуун болгож “Дууны өндөрцөөр магадлах арга”-аар өгүүлбэрийн өргөлтийг тогтоож аялгын давхаргатай уялдуулан аясын бүтцийн өгүүлбэрийн өргөлтийг судалжээ. Өгүүлбэрийн өргөлт нь адил бус төрлийн өгүүлбэрт адил бусаар тархдаг. Өгүүлбэрт өргөлтийн тоо нь аясын хэлхцийн тооноос тогтоогдоно. Монгол хэлний цахар аман аялгууны өгүүлбэрийн өргөлтийн үүрэг гүйцэтгэж байгаа үгийн дууны өндөрц, уртац ба хүчилцийн байршлыг судалж, хүүрнэх өгүүлбэр, асуух өгүүлбэр, захирах, хүсэх өгүүлбэрт өгүүлбэрийн өргөлт тусч байгаа үгийн өндөрц ба хүчилцийн байршлын загвар нь дан үгийн өндөрц ба хүчилцийн байршлын загвартай адилхан байна. Зөвхөн анхааруулах өгүүлбэрт хүчилцийн байршлын загвар нь дан үгийн хүчилцийн байршлын загвартай зөрүүтэй гэх мэтээр олжээ (Хөх Чэжүнжав, 1999, х.102).


Өгүүлбэрийн өргөлтийн судалгааны байдлыг ерөнхийд нь үзвэл, уламжлалт хэлний шинжлэл хэдийгээр аль эрт дурдаж өнгөрсөн боловч түүний тухай гүнзгийрч шинжилсэн бүтээл гэж байдаггүй. Туршилт авианы шинжлэлээс мөрдвөл өгүүлбэрийн өргөлтийн мөн чанарын тухай шинэ үзэлт илэрсэн мөртөө шинэ судалгааны арга мэргэжил ч улирч буй. Гэвч мөн анхны шат буюу сүвэгчлэлийн шатандаа буй

(Монгол хэл бичиг судлах газар, 2005, х.112).

Монгол хэл бол эгшиглэнт хэл биш. Монгол хэлний өргөлт нь үгсийн сангийн утгыг илтгэхгүй мөртөө хэлбэр зүйн утгыг ч илтгэдэггүй. Иймээс монгол хэлэнд өргөлт байх эсэх нь тийм ч чухал биш, харин хамгийн чухал нь дууны өндөрц, дууны хүчлэл зэрэг олон элементүүдийн монгол хэлний үгсийн дундах тархалтын модель тархалтын жим хууль жич тэдгээрийн өргөлттэй үед хэрхэн нөлөөлөх асуудал юм. Нэн чухал нь түүхэн харьцуулсан авиа зүйн зогсцоос үзвэл үгийн өргөлт нь монгол хэл цаашлан хэлний дууны ухааны инженерингт шинжлэх ухаан ч гэрч баримт олгох явдал болох бөгөөд тус асуудлыг шийдвэрлэх төдийгүй ч Монгол хэл, цаашлаад Алтайн язгуур хэлний түүхэн харьцуулсан авиа зүйн судалгааг улам ахиулдаг юм (Төмөртоого, 2017, х.89). Доорх монгол хэлний өгүүлбэрийн өргөлтийн дууны ухааны илрэх байдлыг харвал:

Зураг 1

Дууны хүч



Монгол хэлний өгүүлбэрийн өргөлт нь голдуу авианы өндөрцийн шугам ()-ийн өндөрц давтамжийн чиглэл тийш хувирах товойлт ()-ийн шинжээр илэрдэг. Жишээлбэл зураг нэг бол “Мал нь тарга хүчтэй сайн байсан юм.” (MAL NI ## TARGV HUCU-TEI ## SAYIN # BAYI/GSAN YVM) гэх өгүүлбэр байна. Өгүүлбэр дэх хар шугам нь дууны өндөрцийг илтгэж байгаа болно.

Судалгааны үр дүн

Дээрх зургаас үзвэл, өгүүлбэр “Мал нь тарга хүчтэй сайн байсан юм.”-д “m6ln\43G\t_he:\sE:m\” (авианы SAMPA –М галигаар тэмдэглэв) зэрэг өргөлттэй үенүүдэд дууны өндөрцийн

шугамууд нь тус тус илэрхий дээш товойсон байдалтай. Монгол хэлний өгүүлбэрийн өргөлтийн дууны ухааны илрэлээс үзвэл, дууны өндөрцийн онцлог шинжийг тусгахыг дуунд дууны хүчилцийг ч хамтад нь ярих чухалтай. Гэхдээ үг ярианд дууны өндөрц ба хүчилцийн шугамын хувиралтын хандлага нь үндсэндээ адилавар байдаг (Хасчимэг, 2000, х.22). Өгүүлбэрийн өргөлттэй хэсэгт дууны өндөрцийн шугам нь дээш товойхын хамт хүчилцийн шугам нь ч илэрхий дээш товойсон байдалтай. Энгийн ярианы урсгалд олонхдоо дууны өндөрц ба хүчилц нь өгүүлбэрийн эхэнд харьцангуй өндөр хүчтэй байж өгүүлбэрийн эцэст харьцангуй буурай нам шинжтэй байж. Өндөрцийн шугам ба хүчилцийн шугам нь дээрээс доошлох хандлагыг нь журамлана. Энэ нь яг Crutenden (1986 он)-ы хэлсэн шигээр бусад физиологийн нөхцөл бүр мөсөн адилхан байдалд дууны хөвчийн их бага нь шууд дууны өндөрцийн давтамжийг нөлөөлдөг гэсэнтэй нийцэж буй. Ямар нэг өгүүлбэрийг авиалах явц дунд, дууны хөвч аажмаар доошлохыг дагалдан түүний өндөрц ч аажмаар доошилдог байна. Иймээс энгийн ярианы дунд, өгүүлбэрийн эхний өндөрц ба хүчилц нь өгүүлбэрийн бусад байрынхаасаа харьцангуй өндөр байдаг боловч тэр нь эргэшгүй өгүүлбэрийн өргөлт мөн гэхийг болгоомжлох чухалтай. Зураг 2 ба 3 бол тус тус өгүүлбэр “Цаа бугын эр эм нь бүр эвэртэй.” (CA BVGV-YIN ## ER_E EM_E NI # BOREBER_TEI) ба “Дээврийн хавцаг нь зогсолгүй пас пас хийн чичирхийлнэ.” (DEBUR_E-YIN HABHAG NI # JOGSOL UGEI # PAS=PASHIN ## CECERHILE/N_E) гэх хоёр өгүүлбэрийг уран тод унших үес дэх дууны өндөрц ба хүчлийн шугамын тайлбар зураг болно. Дээрх зургаас үзвэл, өндөрц ба хүчилц нь өгүүлбэрийн эхэнд харьцангуйгаар өндөр байж, өгүүлбэрийн эцэст харьцангуй нам сул байдаг. Тус хоёр хүүрнэх өгүүлбэрийн аяс нь цөм өндрөөс нам тийш аажмаар доошлох хандлагатай. Иймээс “Цаа бугын эр эм нь бүр эвэртэй.” гэх өгүүлбэрт өгүүлбэрийн эхний аялгын үг 1 “Цаа буга”-ийн өндөрц ба хүчилцийн хэмжигдэхүүн нь хамгийн их байдаг. (зураг 2). Гэвч тус өгүүлбэрт өгүүлбэрийн үүргийг даалцаж байгаа нь “Цаа буга” гэх үг биш. Харин “эр эм нь” гэх үг болно. Тус үгийн өндөрц ба хүчилцийн шугам илэрхий дээш товойн, өндөрц хүчилцийн хувирах хандаш нь үндсэндээ нэгдмэл шинжтэй байдаг. Өгүүлбэр “Дээврийн хавцаг нь зогсолгүй пас пас хийн чичирхийлнэ.” (зураг 3) -д ч өгүүлбэрийн үүргийг даалцаж байгаа нь өгүүлбэрийн эхэн дэх “дээврийн” гэх үг биш, харин “зогсолгүй” гэх үг болно.

Дүгнэлт

1.Өгүүлбэрийн аяс ба өргөлтийн хамгийн чухал болох дууны ухааны илрэх хэлбэр бол өндөрц болох мөртөө өргөлт нь өгүүлбэрийн илрэх чухал арга хэлбэр болно. Өгүүлбэрийн аяс болон өргөлт бол органик нэгдмэл харьцаатай байдаг. Хөхөөс өгүүлбэрийн аяс жич өгүүлбэрийн авианы өндөрцийн тухай ярихдаа “Зөвхөн өгүүлбэрийн эцсийн аясын өндөр намаар баримжаа болгож, эл төрлийн өгүүлбэрийн аясын хэв загварыг гаргаж болохгүй” гэж дурдсан мөртөө “Эрхбиш хятад хэлний өгүүлбэрийн аясын судалгаан дахь өгүүлбэрийн аясын цараа ба аясын бүлгийн цараа жич дууны өндөр шугам ба нам шугамыг хараанаас өгүүлбэрийн аяс жич өгүүлбэрийн өргөлтийг судлах зэрэг үзэлтүүдийг бодол хэрэгтэй гэж чухалчилсан байна (1). Үүнд суурилан, өгүүлэл “Монгол хэлний баримжаа авианы суурилсан уншлагын материалын өгүүлбэрийн тэнцэх хэмжээний судлал” (Үзэсгэлэн, 2011) нь Halliday –ийн “Аясын бүлгийн онол” (2) ба Ши Пян-ын “Аясын тогтолцооны онол” (3)-ийн сэтгэцэд суурилан монгол хэлний баримжаа авианы дөрвөн төрлийн өгүүлбэрийн аясын цараа, аясын бүлгийн цараа-ын өргөцийн хувиралт ба тэнцэх хэмжээн тархцын онцлог жич тэдгээрийн харьцааг шинжлэн, монгол хэлий дөрвөн төрлийн өгүүлбэрийн аясын үндсэн моделийг гаргахаар оролдов. Өгүүлэл “ Монгол хэлний уншлагын материалын өгүүлбэрийн өргөлтийн туршилт судлал” (Ванг Шү Чин, 2008) нь хэл зүйн өргөлтөөр судлагдахуун болгож дууны ухааны аргаар монгол хэлний өгүүлбэрийн өргөлтийн асуудлыг шинжилж “Дууны өндөрцөөр магадлах арга” –аар өгүүлбэрийн өргөлтийн тодлохын дуу өгүүлбэрийн өргөлт ба өргөлтийн аясыг уялдуулан, өгүүлбэрийн аясын царааны хэвчээнд өгүүлбэрийн өргөлтөд задлал хийсэн байна.

2.Үүнээс үзвэл, монгол хэлний өгүүлбэрийн өргөлт нь хэдийгээр авианы өндөрцтэй шууд харьцаатай боловч, дан ганц авианы өндөрцийн муруй шугамын өнгө давхаргын хувиралтаас шалтгаалах бус харин гүн давхаргын үүднээс өгүүлбэрийн өргөлт жич аясын хоорондох харьцаа, өгүүлбэрийн өргөлт жич үгсийн холбоо, өгүүлбэрийн бүтцийн хоорондох харьцаа жич адил бусын хэлэх зорилгоос үүсэх адил бусын аяс бүхий өгүүлбэрийн өргөлт зэргийг шинжлэх хэрэгтэй.

Ном зүй

- Баярмэнд. (2012). Монгол хэлний үгийн эхний бус үеийн богино эгшгийн дуун авиа задлал. *Дундад улсын монгол сэтгүүл. 5-р хугацаа*
- Богуйлан. (2017). Монгол хэлний туршиц авиа зүйн хэрэглээний тухай. *Монгол судалгааны чуулган. 1-р хугацаа*
- Бохуайчил. (1989). Монгол хэлний Цахар аман аялгууны эгшиг авианы судлал. *Үндэстний хэл бичиг сэтгүүл. 4-р хугацаа*
- Бойжуй, Мөнхбучи. (2008). Монгол хэлний Шулуун хөх хошууны эгшиг авианы авиалбарын систем. *Өвөр Монголын Үндэстний их сургуулийн сэтгүүл. 5-р хугацаа*
- Хөх Чэжүнжав. (1999). *Монгол хэлний авианы дууны ухааны задлал нь. Хөх хот: Хөх хот өвөрмонголын их сургуулийн хэвлэлийн хороо*
- Өвөр монголын их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн Монгол хэл бичиг судлах газар. (2005). *Одоо үеийн Монгол хэл. Хөх хот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.*
- Төмөртоогоо, Д. (2017). *Монгол хэлний түүхэн авиа зүйн үндэс.* Улаанбаатар: “Соёмбо принтинг” ххк-д хэвлэв.
- Хасчимэг. (2000). Монгол хэлний Ойрад аялгууны 1-р үеийн эгшиг авианы дуу авианы задлал. *Өвөр Монголын Их сургуулийн сэтгүүл. Нэмэлт дугаар.*

An articulatory synthesis of sentence accent In mongolian language

Wang Guo Bin*
Linguistics Department,
School of Mongol Studies,
Inner Mongolia Normal University

Abstract

The study presents how and where ‘sentence accent’ is articulated and developed in the Mongolian language. The nature of accent is the form of vowel appearance in the main part of communication processes, but the speech sound which the articulator is going to deliver is the main idea. The sentence accent distinguishes the meanings. In using praat, the study mainly does an articulatory synthesis of speech sound in phonetics and defines the loudness or softness of speech based on the analysis of three elements of sound. These elements define the sound strength and length. In applying these elements, the study defined the sound strength and proved it with many facts and examples.

Keywords

The accent, acoustic, pitch, phonetics

* Corresponding author: 66811344@qq.com